



ДА ХҮРЭЭ ТРЕЙД ХХК

**“АВТО ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



**БАЙРШИЛ: УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ,
9-Р ХОРООНЫ НУТАГ**

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА -----	2
1.1. Төслийн товч танилцуулга -----	2
1.1.1. Цахилгаан -----	3
1.1.3. Усан хангамж -----	3
1.1.5. Хог хаягдал -----	4
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ -----	5
2.1. Төслийн байршил -----	5
2.2. Байгаль орчны төлөв байдал -----	5
2.2.1. Газрын гадарга, газарзүйн нөхцөл -----	5
2.2.2. Геологийн тогтоц -----	5
2.2.4. Уур амьсгал -----	6
2.2.5. Хөрсөн бүрхэвч, түүний онцлог -----	7
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ -----	8
3.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл -----	8
3.2. Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл -----	8
3.4. Гадаргын болон газрын дорх усны бохирдол -----	8
3.5. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл -----	8
3.6. Төсөл хэрэгжих орчны түүх, соёлын дурсгалт зүйлс -----	8
Дөрөв. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө -----	9
Тав. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө -----	11
Зургаа. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө -----	12
Долоо. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө -----	13
Найм. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр -----	13
Ес. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө -----	13
Арав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв -----	14
Арван нэг. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө -----	14

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


1.1. Төслийн товч танилцуулга

“Да хүрээ” авто худалдааны төв нь БЗД-ийн 9-р хорооны нутаг дэвсгэрт 6,5 га талбайд худалдаа үйлчилгээний 5 байр, битүү болон задгай авто худалдааны төв, сэлбэгийн дэлгүүр, зоогийн газар зэрэг 200-аад барилга байгууламж, стандартын дагуу засч тохижуулсан худалдах авто машины 1500, үйлчлүүлэгчдийн 300 гаруй зогсоолтойгоор, байгаль орчинд ээлтэй 100 хувь “Эко” орчныг бүрдүүлэх хэтийн зорилготойгоор ажиллаж байна.

Дэд бүтцээс алслагдсан байдал, газар ашиглалт, гудамж замын сүлжээ, үйлчилгээний таатай орчин, хөрс агаарын бохирдлыг бууруулах зэрэг тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхээр Улаанбаатар хотын 2020-2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, “Шархад дэд төв”-ийн төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан “Да хүрээ” авто худалдааны төв байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний дагуу “Үйлчилгээтэй 2 давхар дулаан зогсоол”-ын барилга угсралтын ажлыг 2019 онд эхлүүлж, 2 тэрбум орчим төгрөгийн өртөгтэйгөөр санхүүжүүлэн бариулж, ашиглалтад оруулсан.

Тус төсөл нь худалдаа үйлчилгээний барилгуудыг иж бүрнээр нь төлөвлөж, авто зам, ногоон байгууламжийг гэр хорооллын бүсэд нэмэгдүүлэн, хотын эдийн засаг, дэд бүтцийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахын зэрэгцээ эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрэлдэх олон талын ач холбогдолтой юм.

Байгаль орчны зөвлөх үйлчилгээний эрх бүхий мэргэжлийн байгууллага болох “Эко Цогц Шийдэл” ХХК-тэй холбогдох хууль тогтоомжийг үндэслэн байгуулсан гэрээний дагуу “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний” тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 2025 оны хугацаанд хэрэгжих байгаль орчны менежментийн төлөвлөгөөг зохих арга зүйн дагуу боловсруулсан болно.



Зураг 1. Эзэмшлийн нийт талбай

1.1.1. Цахилгаан

Цахилгаан эрчим хүчийг Улаанбаатар хотын нэгдсэн сүлжээнээс хангадаг. БЗД-ийн 9 дүгээр хороонд байрлах “Да хүрээ трейд” ХХК-ийн эзэмшилд Улаанхуаран дэд станцын Манлай фидерийн КТПН-3558 дэд өртөөний 10/400 кВА хүчин чадал бүхий трансформатор, Шар хад фидерийн КТПН-5836 дэд өртөөний 10/630 кВА хүчин чадал бүхий трансформаторуудтай.

Тус аж ахуйн нэгж нь цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ зэргийг удирдлага болгон, мөрдөж ажилладаг бөгөөд сарын цахилгаан эрчим хүчний дундаж хэрэглээ 170,000 кВт.ц (дундаж хэрэглээг 2ш КТПН-ийн жилийн тоолуурын заалтыг хувилж тооцож гаргасан) байдаг.

1.1.2. Дулаан хангамж

Оффис болон үйлчилгээний зориулалт бүхий барилга байгууламжуудыг “Дакон” брендийн цахилгаан 60, 48, 24 кВт-ын цахилгаан зуухаар халаадаг.

1.1.3. Усан хангамж

УСУГ-тай хийсэн гэрээний дагуу 17-р хорооны цэвэр усны худагнаас цэвэр усны шугамыг татуулан усны нөөцлүүр бүхий саванд цуглуулж хэрэглээний төлбөрийг тоолуурын заалтаар барагдуулдаг.



Зураг 3. Үйлчилгээний байран дахь худаг



Зураг 2. Бохирын цооног

1.1.4. Ариун цэврийн байгууламж

Тус худалдааны төвийн “Худалдаа үйлчилгээ”-ний 5 байран дотор 6, хашаан дотор 2 буюу нийт 8 ариун цэврийн стандартын шаардлага хангасан бие засах өрөөг байгуулан, бохирын цооногт хуримтлуулан, эрх бүхий байгууллагуудтай хийсэн гэрээний дагуу шингэн хаягдлыг зайлуулж ажилладаг.

Тухайлбал: “Голден Эко” ХХК-тай бохир ус тээвэрлэлтийн 22/07 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна.



Зураг 4. Ариун цэврийн байгууламж

1.1.5. Хог хаягдал

Үйлчилгээний төв болон худалдаа эрхлэгчдээс гарах өдөр тутмын хог хаягдлыг ангилан ялган зориулалтын хогийн саванд байршуулж дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар IV ийн гэрээт байгууллага хог тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг “Үйлст Мандал” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу зайлуулдаг.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн байршил

“Да Хүрээ” Автомашины худалдаа, үйлчилгээний төвийн байршил нь Баянзүрх дүүргийн 9-р хорооны нутагт хамаарна.

2.2. Байгаль орчны төлөв байдал

2.2.1. Газрын гадарга, газарзүйн нөхцөл

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг нь Хөрс-Газарзүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт, тухайлбал Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд шувтрага үзүүрт Туул голын өргөн хөндий, ай сав цутгал голуудын бэлчирт байрладаг,

Ус хагалбарын хувьд Умард мөсөн далайн ба Төв Азийн гадагш урсгалгүй голуудын ай савыг заагласан усан хагалбарын хэсэг дайрч өнгөрдөг онцлогтой. Гадаргын хэлбэр дүрсийн хувьд нам уулс болон түүний энгэр, бэлийн системд орших учир зонхилох хөрсний шинж чанар, тархалтанд хотгор, гүдгэрийн байдал голчлох нөлөө үзүүлсэн байна.

“Да Хүрээ Трейд” ХХК-ийн автомашин, сэлбэгийн худалдаа, үйлчилгээний төвийн чиглэлээр ашиглаж буй тус газар нь Шархад уулын урд энгэр, Цагдуулт уул, Улиастайн голын баруун, Туул голын сав газрын хойд талд байрлана. Эдгээр уулс нь эгц хажуутай, хурц шовх оройтой, гарш хяруудыг үүсгэсэн байдаг.

Дээрх уулс хоорондын хөндий, газрын гадаргын харьцангуй өндөршлийн зөрүү ихэвчлэн 150-200 м байна.

Туул голын хөндийн ай савын татмын үнэмлэхүй өндөр 1250-1345 м бөгөөд өргөний хэмжээ 1.2-4.0 км байдаг. Толгойт, Баянхошуу, Баянцогт, Хойд Баян, Цагдуулт зэрэг нам уулсын мужийн үнэмлэхүй өндрийн хэмжээ 1515-1831 м ба тэдгээрийн хажуу ташлаг, энгэр, бэлийн налуу ихэвчлэн 15-20 хэм зарим тохиолдолд 30-35 хэм байдаг. Нэлээд өндөр өргөгдсөн уулсын мужийн хажуу ташлаг, энгэр, бэл, хормойг хөндлөн хэрчсэн олон тооны хуурай сайр, гуу жалга ховил түгээмэл ажиглагддаг.

2.2.2. Геологийн тогтоц

Тектоник мужлалын хувьд энэхүү район нь Хэнтийн геосинклиналь хотгорын хэмжээнд хамаарагдана. Судлаачид энд геологийн янз бүрийн эрин, цаг үеүүдэд үүссэн найрлага тогтоцын хувьд бие биеэс ялгаатай хурдас чулуулгууд үүссэн болохыг нэгэнт тогтоосон байдаг. Энд дунд палеозойн элсэн чулуулгууд, алевролитууд, давтамжит тогтоцтой багц хас болон туффитүүд, доод цэрдийн конгломератууд, бүдүүн ширхэгт элсэн чулуулгууд, гуравдагч галавын настай алаг өнгийн толшууд мөн тэрчлэн дөрөвдөгчийн байран, хажуугийн хажуу хормойн, гол хормойн, голын хурдсууд тархан хөгжсөн байна.

Дунд палезойн бараан өнгийн цахиурлаг, шаварлаг алеворолитууд, жижиг ширхэгт элсэн чулуулгууд, давтамжит хас болон туффитүүд нь Богд уулын хойт арын хажуу, Сонгино хайрхан, Улиастайн гол, Толгойт-Мах комбинатын районуудаар өргөн тархжээ.

Мезойн геотехникийн хөгжил, эх газрын нөхцөлд явагдсан бөгөөд дунд пилезойн талст суурин дээр давхцмал структурыг үүсгэж, магмын үйл ажиллагаа хүчтэй явагдсанаар ялгагдана.

Доод цэрдийн конгломератын хайргын найрлалгыг палезойн сайн мөлгөржсөн элсэн чулуулгууд, занарууд, ховроор боржин чулуулгууд бүрдүүлнэ. Хайрга нь саарал, шаравтар-саарал, элс, шаварлаг материалаар цементлэгдсэн байдаг. Доод цэрдийн конгломератуудын зузаалаг дунд ургамлын үлдэгдэл агуулах бага зузаантай бүдүүн ширхэгтэй элсэн чулуулгийн үеүүд тохиолдоно.

2.2.4. Уур амьсгал

Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -49°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 39°C хүрдэг, үнэмлэхүй их бага температурын агууриг нь (88.0°C) эрс тэс ялгаатай бөгөөд ийм их зөрөө дэлхийн аль ч улсын нийслэлд гардаггүй байх.

Жилийн дундаж температур нь -3.0°C , хамгийн хүйтэн I сарын температур -26.0°C байх бөгөөд -30.0°C -аас бууж хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим байна.

Улаанбаатар хотод жилд дунджаар 238мм тунадас унаж, ууршилт нь 648мм болдог. Чийглэгийн байдал 0.36 байдаг. Цасан бүрхэвч XI сарын 10-ны үед тогтож III сарын хорьд хүртэл 130 орчим хоног 18 см орчим зузаан цастай байна. Ууландаа цасны зузаан их, цасан шуургатай өдөр 10 орчим өдөр байдаг ажээ. Жилийн хамгийн богино өдөр өвлийн туйлын өдөр XII сарын 22-нд болох бөгөөд энэ өдөр өдрийн урт 8 цаг 24 минут үргэлжилнэ. Энэ өдөр Улаанбаатар хотод үдийн нарны тусгалын өнцөг 18.5° болдог.

Улаанбаатар хотод хүйтрэлтгүй үргэлжлэх хугацаа V сарын 29-ны орчмоос IX сарын 1-ний орчим хүртэл буюу 90 гаруй хоног байна. Өөрөөр хэлбэл энэ хугацаанд агаарын температур 0° -аас доош буухгүй гэсэн үг. Жил жилийн онцлогоос болоод энэ хоногийн тоо арай олон, цөөн байж болох нь тодорхой, жилийн хамгийн дулаан сар нь VII сар, дундаж дулаан нь 17°C бөгөөд хамгийн их халуун болсон нь 38.6°C хүрсэн. Зундаа 30°C -аас давж дулаарах өдөр 10 орчим, хоногийн дундаж дулаан 10°C давж дулаарах өдөр хавар VI сарын 6-аас намар VIII сарын 25 хүртэл 80 орчим хоног байдаг аж. Ган болох, чийглэг зун болох магадлал 30 орчим хувь.

Улаанбаатар хотод манай орны ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд хойд, баруун хойд чиглэлийн салхи давтагтдагийг болно. Тус газар хойноос нийт салхины чиглэлийн 20%, баруун хойноос 22.1%, баруунаас 13.5% давтагдалтай байдаг.

Салхины хурдны олон жилийн дундаж нь төдий л ихгүй ойролцоогоор 1.5-2.3 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул ихэвчлэн намуун байдаг. Харин салхины их хурдны хувьд ихэнх саруудад 15 м/с-с их, хаврын саруудад 28 м/с хүрч байжээ.

2.2.5. Хөрсөн бүрхэвч, түүний онцлог

Улаанбаатар хот нь газрын гадаргын хувьд ерөнхийдөө уулсын урд энгэр бэлд байрлах бөгөөд Хөрс Газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын холимог бүсшилийн Хангай Хэнтийн их муж, Өмнөдийн дэд мужын 52-р тойрогт багтана. Эзэмшлийн талбай нь ерөнхийдөө Хар хүрэн хөрсний хэв шинж тогтворжсон байна.

Геоморфологийн онцлог ялгаатай байдлаас шалтгаалж Хархүрэн хөрсний тархалт нь дэд хэв шинж, төрлийн түвшинд харилцан адилгүй байна. Жишээ нь: Уулын орой хяраа дагаад харьцангуй өндөрлөг газраар Чулуурхаг нимгэн Хархүрэн, нам ухаа толгодорхог газраар Сайргархаг Хархүрэн, тэгшивтэр талархаг газраар Ердийн Хархүрэн, нам уулсын хөндий хонхор газраар Элсэрхэг Хархүрэн хөрс зонхилон тогтворжсон байна.

Баянзүрх дүүргийн 9-р хорооны нутгийн хөрсөн бүрхэвчийн талаарх газар зохион байгуулалт болон мэргэжлийн байгууллагуудын урд өмнө хийгдсэн судалгаагаар хөрсний хэв шинжээр 7 төрлийн хөрс тархсан гэж үзжээ. Үүнд:

1. Уулын тайгын ширэгт хөрс
2. Өндөр уулын бүдүүн ялзмагт хөрс
3. Уулын хар хүрэн хөрс
4. Уулын нугын хөрс
5. Уулын ойн бараан өнгийн хөрс
6. Ердийн хар хүрэн хөрс
7. Цайвар хүрэн хөрс

Үүнээс эзэмшлийн талбай дахь хөрсний онцлог гарал үүсэл, шим тэжээлийн агууламж нь ердийн Аллювийн нугын сулавтар хөгжилтэй, хар хүрэн гэсэн хэв шинж зонхилно.

“Да Хүрээ” авто худалдааны төвийн ашиглалтын талбай нь нэлэнхүйдээ бетонон болон асфальтан хучилт бүхий цардмал талбайтай. Харин эзэмшлийн талбайн хойд талд байрлах 1331 м² хайрган хучилт бүхий талбайг автомашины түр зогсоол хэлбэрээр ашиглаж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг БОННУ-ний тайланд тусгагдсанаар газрын ашиглалтын хэлбэр, тэр дундаа дэд бүтцийн төлөвлөлт, цахилгаан дулаан хангамж, бохирын шийдэл, хог хаягдлын менежмент зэргээс үүсэх болзошгүй эрсдэл дараах байдлаар үнэлсэн байдаг.

3.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас гадаад орчны агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн эрчим бага ангилалд хамаарна.

3.2. Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Автомашины тос, тосолгооны материалыг ил задгай хаях, хог хаягдлыг ангилан ялгах, ачих зайлуулах нөхцөлийг зөв сонгоогүйгээс эзэмшлийн талбай орчим болон хурын усаар дамжин ойролцоох газрын хэвгий хэсэг бохирдох, улмаар хүнсний гинжин хэлхээгээр дамжин хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байдаг.

Хөрс нефтийн гаралтай бүтээгдэхүүнээр бохирдсон тохиолдолд тэр нь удаан хугацааны туршид хөрсөнд хадгалагдаж задралынхаа явцаар хөрсний үржил шим, ургамлын өсөх орчинг муутгана. Ингэснээр хөрсний ялзмагийн бодисын хэмжээг багасгаж, хар тугалгын хэмжээг нэмэгдүүлж улмаар ургамлын өсөлт зогсон үржил шим нь бүрэн алдагддаг. Ургамал болон бусад бичил биет амьтан зоопланктон хордож үхэлд хүрнэ.

3.4. Гадаргын болон газрын дорх усны бохирдол

“Да Хүрээ” авто худалдааны төвийн ахуйн хэрэглээнд ашиглагдах усыг УСУГ-ын гүний худгаас хангадаг ба төслийн зүгээс гадаргын болон гүний усанд шууд үзүүлэх нөлөөлөл байхгүй.

3.5. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Амьтны аймагт шууд нөлөөлөх хүчин зүйл байхгүй.

3.6. Төсөл хэрэгжих орчны түүх, соёлын дурсгалт зүйлс

Төсөл хэрэгжих талбайн орчимд түүх соёлын дурсгалт зүйлс болон археологи, палентлогийн олдвор тэмдэглэгдээгүй байна.

3.7. Ажилчдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Ажилчдын эрүүл мэндэд шууд болон дам байдлаар үзүүлэх нөлөөлөл байхгүй.

Дөрөв. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Зарцуулах мөнгөн дүн мян.төг	Баримтлах стандарт аргачлал
Агаарын чанар			
Агаар орчинд бохирдол үүсэх	“Да Хүрээ” авто худалдаа, үйлчилгээний төвийн зогсоолд ил байрлаж буй автомашиныг асаалттай хэт удаан зогсоохгүй байх, хөдөлгүүр халаах, нормалдах цагийн хязгаар тогтоох	500.0	MNS 4585:2015 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS5885:2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” MNS6063:2010
	Битүүмж бүхий дулаан зогсоолд автомашин байршуулж буй худалдааны төвүүдийн агаар сэлгэгчийн ажиллагаанд тогтмол хяналт тавих	-	“Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ” MNS4990:2000 “ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага” MNS ISO226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ
Хөрс, ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл			
Хөрсөнд элэгдэл, эвдрэл, бохирдол үүсэх	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан ялгах хогийн савуудыг сайжруулах	1,000.0	MNS 5342:2007 “Автомашин зогсоол, ангилал, ерөнхий шаардлага”
	Тос, тосолгооны материал асгарч алдагдсан тохиолдолд түүнийг цэвэрлэх хэрэгсэлээр хангах, хөрсөнд нэвчихээс хамгаалах	500.0	Барилгын орчны тохижилтын ажил, БНБД 3.0106-90
	Тогтсон маршрутын дагуу тээврийн хэрэгсэл зорчих тэмдэг тэмдэглэгээг сайжруулах	500.0	MNS 6426:2013, MNS 4597:2013 Авто Замын тэмдэглэгээ
Усны чанарын талаар			

Усны нөөц хомсдох, бохирдох	Хурын ус хуримтлуулах сав бэлдэж, хуримтлагдсан усаар зүлэг ногоо услах	500.0	MNS 4586-98 Усан орчны чанарын үзүүлэлт
	Байгаль орчинг бохирдуулахгүй байх анхааруулга, санамж бүхий самбар хийх	500.0	“Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 тоот тушаалын хавсралт MNS 13.060.50 Усны чанарын стандарт
Амьтны аймаг			
Амьтдын дайжилт, амьдрах орчны хязгаарлалт, доройтол	Зам талбай засах, барилгын ажил хийгдэх үед дуу чимээ ихтэй техник хэрэгслийг өдрийн цагаар ашиглах	-	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.
	Барилгын ажлыг шөнийн цагт гүйцэтгэхийг хориглох	-	Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
Төслийг хэрэгжүүлэхэд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын урьдчилсан дүн		3,500.0	

Тав. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян. төг	Нийт зардал мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ашиглалтын талбай дахь хөл газрын ургамлыг цэвэрлэж, таримал ерхөг, согоовор тарьж, зүлэгжүүлэх	Халцарч, эвдэрсэн, цардаж зам талбайг зүлэгжүүлэх, хайлаас тарих	Эзэмшлийн талбайд	м.кв	300	5.0	150.0	2025	MNS 6260: 2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах
	Тэрбум мод төслийн хүрээнд эзэмшлийн талбайн сул газарт мод тарих		Эзэмшлийн талбайд	ширхэг	20	30.0	600.0	2025	
	Нийт						750.0		

Зургаа. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян. төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Хог хаягдлыг ил задгай хаяснаас хөрс, ургамлыг бохирдуулах	Хатуу хог хаягдлын тогтсон цэгийг тэмдэгжүүлэх, ангилах	Эзэмшлийн нийт талбайд	Төг	500.0	1	500.0	Жилдээ	Хог хаягдлын тухай хууль,
2	Хог хаягдлыг ил задгай хаяснаас хөрс, ургамлыг бохирдуулах	Аюултай хог хаягдлыг ахуйн гаралтай хог хаягдлаас тусад нь савлан цуглуулна. Аюултай хог хаягдал болон шатах тослох материал бүхий сав баглаа боодлыг хадгалах байгууламжийг стандартад нийцүүлэх		Төг	500.0	1	500.0	Жилдээ	Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
	Нийт						1,000.0		

Долоо. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайн ойролцоо буюу эдэлбэр газарт түүх соёлын дурсгалт зүйлс болон археологи, палеонтологийн олдвор байхгүй.

Найм. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж, тоо	Нэгжийн зардал, мян. төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	2	ҮИ, IX сар	2	300.0	600.0		MNS: 6431:2012 MNS: 5367:2004
2	Хөрсний хүнд металлын бохирдол	3		2	200.0	1,200.0		MNS: 5850:2019
3	Хөрсний агрохими	3		2	50.0	300.0		MNS 3298:1991
4	Дуу чимээ, шуугианы түвшин	2		2	100.0	200.0		MNS 5003: 2000
5	Агаарын чанар	2		2	200.0	800.0		MNS: 4585:2016
6	Ундны усны шинжилгээ	1		2	300.0	600.0		MNS 0900:2018
	Нийт					3,700.0		

Ес. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөвмян. төг	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
	1	2	3	4
1	Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хамгаалах талаар сургалт семинарыг тогтмол зохион байгуулж. хамруулах	500.0	Менежер	
2	Ажиллагсдыг галын аюулгүй байдал, гэнэтийн осол аваарын үед дадгаажуулах сургалт зохион байгуулах	500.0	Менежер	БЗДОБГ-тай хамтран
3	Тос, тосолгооны материал, аюултай хог хаягдлыг түр, хадгалах, зайлуулах стандартыг баримталж ажиллах талаар сургалт зохион байгуулах	500.0	Менежер	
	Нийт	1,500.0		

Арав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

№	Ажлын төлөвлөгөө	Нэгжийн зардал, мян. төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,500.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	750.0
3	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,000.0
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,700.0
5	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,500.0
Нийт зардал мян.төг		10,450.0

Арван нэг. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Нийслэлийн БОГ-т	Бичгээр	Тухайн оны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг	2025.11.01-ний дотор	-	Менежер	“Да Хүрээ” төв оффис
2	БОУАӨЯ	Цахимаар	Дараа оны БОМТ-г батлуулах	2025.12 сард багтаан	-	Менежер	